

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Үндэсний урлагийн их театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/250/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: И.Эрдэнэцэцэг Утас: 260512 Цахим хаяг: erdenetsetsegi@audit.gov.mn Аудитор: С.Билгүтэй Утас: 261628 Цахим хаяг: bilguteis@audit.gov.mn Ворлдвайд файнэнс аудит ХХК-ийн захирал: С.Оюунгэрэл Утас: 99032466 Цахим хаяг: oyungerels.sag@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ССАЖЗЯ	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ УРЛАГИЙН ИХ ТЕАТРЫН
ЗАХИРАЛ Г.ЦОГГЭРЭЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/400
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үндэсний урлагийн их театрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Үндэсний урлагийн их театрын 75 жилийн ойн арга хэмжээнд зориулж театрын үндсэн үйл ажиллагааны орлогоос 15,928.5 мянган төгрөгийг холбогдох арга хэмжээнд зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус театрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 56,259м² талбай бүхий эзэмшлийн газрын эрхийг Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/98 дугаар захирамжаар хүчингүй болгосон тул данснаас хасах зөвшөөрөл олгох хүсэлтийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй байна.

Бусад асуудал

Тус байгууллагын санхүүгийн тайлангийн аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,318,999,290.55	3,178,460,737.52
33	АВЛАГА	182,900,188.10	1,035,674,243.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	70,000,000.00	926,085,443.00
33500	Бусад авлага	112,900,188.10	109,588,800.00
33510	Байгууллагаас авах авлага	110,867,550.00	109,588,800.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	2,032,638.10	-
35	БАРАА МАТЕРИАЛ	2,136,099,102.45	2,142,786,494.52
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,837,908.16	3,447,572.46
35400	Хангамжийн материал	2,134,261,194.29	2,139,338,922.06
35410	Бичиг хэргийн материал	725,100.00	563,620.00
35420	Аж ахуйн материал	137,979,690.65	120,338,908.85
35470	Бусад хангамжийн материал	1,995,556,403.64	2,018,436,393.21
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,544,231,088.85	1,553,062,796.91
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,544,231,088.85	1,553,062,796.91
39200	Биет хөрөнгө	579,508,017.32	588,522,016.91
39203	Авто-тээврийн хэрэгсэл	331,937,497.50	491,937,497.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	(195,285,323.81)	(263,185,740.31)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	448,182,911.49	483,582,911.49
39206	Хуримтлагдсан элэгдэл	(188,806,554.70)	(258,608,100.12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	206,936,378.58	206,936,378.58
39208	Хуримтлагдсан элэгдэл	(97,218,386.59)	(113,633,741.80)
39214	Бусад үндсэн хөрөнгө	285,312,976.19	285,312,976.19
39215	Хуримтлагдсан элэгдэл	(211,551,481.34)	(243,820,164.62)
39300	Биет бус хөрөнгө	964,723,071.53	964,540,780.00
39301	Програм хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,067,708.47)	(1,250,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	964,540,780.00	964,540,780.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	3,863,230,379.40	4,731,523,534.43
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	27,580,430.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	27,580,430.00
41300	Өглөг	-	27,580,430.00
41360	Бусад өглөг	-	27,580,430.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	12,884,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	14,696,430.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,863,230,379.40	4,703,943,104.43
51	Засгийн газрын хувь оролцоо	3,863,230,379.40	4,703,943,104.43
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,565,541,435.43	1,565,541,435.43
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	1,565,541,435.43	1,565,541,435.43
51200	Хуримтлагдсан үр дүн	2,282,200,993.97	3,122,913,719.00
51210	Өмнөх үеийн үр дүн	1,736,113,890.15	2,280,168,355.87
51220	Тайлант үеийн үр дүн	546,087,103.82	842,745,363.13
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	15,487,950.00	15,487,950.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	3,863,230,379.40	4,731,523,534.43

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	7,771,027,269.99	7,482,192,225.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	260,154,169.99	7,482,192,225.00
120	Нийтлэг татварын бус орлого	260,154,169.99	163,120,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	85,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	85,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	259,718,060.00	163,120,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	351,109.99	-
122	Тусламжийн орлого	-	7,319,072,225.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	7,319,072,225.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	6,149,663,973.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	6,149,663,973.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,169,408,252.00
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	256,205,692.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	913,202,560.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,510,873,100.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,738,830,300.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,738,830,300.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,772,042,800.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	105,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,667,042,800.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,224,940,166.17	6,639,446,861.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,224,940,166.17	6,639,446,861.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,342,998,866.59	6,134,799,099.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,727,197,496.66	4,929,186,678.09
210101	Үндсэн цалин	2,993,458,234.26	3,028,492,377.16
210102	Нэмэгдэл	784,192,830.40	894,500,249.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	551,448,000.92	623,477,799.53
210104	Урамшуулал	398,098,431.08	382,716,252.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	586,384,697.94	613,681,998.62
210201	Тэтгэврийн даатгалын зардал	400,926,275.72	421,439,631.15
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	46,554,149.43	48,994,994.58
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	25,706,733.27	26,508,602.18
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	22,269,806.55	23,172,422.41
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	90,927,732.97	93,566,348.30
2104	Хангамж, бараа материалын зардал	36,084,048.00	16,349,935.28
210401	Бичиг хэрэг	4,646,023.00	3,079,080.00
210402	Тээвэр, шатахуун	8,000,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	383,840.00	397,600.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,054,185.00	12,873,255.28
2105	Нормативт зардал	275,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	275,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	83,385,705.00	48,988,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,825,000.00	-
210604	Урсгал засвар	80,560,705.00	48,988,100.00
2107	Томилолт, зочны зардал	-	87,607,452.00
210701	Гадаад албан томиллолт	-	87,607,452.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	731,092,010.87	243,746,643.65
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	715,579,942.87	237,671,787.65
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	337,100.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	550,000.00	479,656.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	85,756.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,173,700.00	595,200.00
210807	Газрын төлбөр	8,365,512.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	178,579,908.12	195,238,291.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,670,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	173,579,908.12	186,568,291.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	881,941,299.58	504,647,762.29
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	106,708,750.29
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	106,708,750.29
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	106,708,750.29
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	102,696,723.29
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал\	-	4,012,027.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	770,462,400.00	397,939,012.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	47,510,600.00	40,427,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,951,800.00	357,511,212.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	720,000,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	111,478,899.58	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,580,989.58	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	75,897,910.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	546,087,103.82	842,745,363.13
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	546,087,103.82	842,745,363.13

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	7,498,558,375.00	7,390,350,975.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	85,000.00	7,390,350,975.00
120	Нийтлэг татварын бус орлого	85,000.00	-

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	85,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	85,000.00	-
122	Тусламжийн орлого	-	7,390,350,975.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	7,390,350,975.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	6,149,663,973.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	6,149,663,973.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,240,687,002.00
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	256,205,692.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	984,481,310.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,498,473,375.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,738,830,300.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,738,830,300.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,759,643,075.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	105,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,654,643,075.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,367,780,425.00	7,365,954,975.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,367,780,425.00	7,365,954,975.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,415,839,125.42	5,935,221,769.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,729,883,544.48	4,929,186,678.09
210101	Үндсэн цалин	2,993,458,234.26	3,028,492,377.16
210102	Нэмэгдэл	786,878,878.22	894,500,249.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	551,448,000.92	623,477,799.53
210104	Урамшуулал	398,098,431.08	382,716,252.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	586,384,697.94	613,681,998.62
210201	Тэтгэврийн даатгалын зардал	400,926,275.72	421,439,631.15
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	46,554,149.43	48,994,994.58
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	25,706,733.27	26,508,602.18
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	22,269,806.55	23,172,422.41
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	90,927,732.97	93,566,348.30
2104	Хангамж, бараа материалын зардал	22,914,000.00	3,464,700.00
210401	Бичиг хэрэг	2,100,950.00	965,000.00
210402	Тээвэр, шатахуун	8,000,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	383,840.00	397,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,429,210.00	2,102,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	101,447,500.00	15,760,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	27,300,100.00	15,760,000.00
210602	Тавилга	1,177,500.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,569,900.00	-
210604	Урсгал засвар	64,400,000.00	-
2107	Томиллолт, зочны зардал	-	87,607,452.00
210701	Гадаад албан томиллолт	-	87,607,452.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	970,209,383.00	251,061,771.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	954,771,015.00	249,915,415.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	337,100.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	550,000.00	479,656.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	85,756.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,100,000.00	666,700.00
210807	Газрын төлбөр	8,365,512.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	34,459,170.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	34,459,170.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	951,941,299.58	1,430,733,205.29
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	1,032,794,193.29
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	1,032,794,193.29
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	1,032,794,193.29
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	102,696,723.29
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	4,012,027.00
2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	926,085,443.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	770,462,400.00	397,939,012.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	47,510,600.00	40,427,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,951,800.00	357,511,212.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	720,000,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	181,478,899.58	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,580,989.58	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	145,897,910.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	130,777,950.00	24,396,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	130,787,950.00	24,396,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	130,787,950.00	24,396,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	130,787,950.00	24,396,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	130,787,950.00	24,396,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(130,787,950.00)	(24,396,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(10,000.00)	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,000.00	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,565,541,435.43	15,487,950.00	1,736,113,890.15	3,317,143,275.58
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,565,541,435.43	15,487,950.00	1,736,113,890.15	3,317,143,275.58
3	Тайлант үеийн үр дүн	-	-	546,087,103.82	546,087,103.82
4	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,565,541,435.43	15,487,950.00	2,282,200,993.97	3,863,230,379.40
5	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(2,032,638.10)	(2,032,638.10)
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,565,541,435.43	15,487,950.00	2,280,168,355.87	3,861,197,741.30
7	Тайлант үеийн үр дүн	-	-	842,745,363.13	842,745,363.13
8	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,565,541,435.43	15,487,950.00	3,122,913,719.00	4,703,943,104.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,307,313,900.00	6,046,967,249.71	(260,346,650.29)	95.9
12	Татварын бус орлого	6,307,313,900.00	6,046,967,249.71	(260,346,650.29)	95.9
122	Тусламжийн орлого	6,307,313,900.00	6,046,967,249.71	(260,346,650.29)	95.9
122005	Төсвөөс санхүүжих	6,307,313,900.00	6,046,967,249.71	(260,346,650.29)	95.9
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,307,313,900.00	6,046,967,249.71	(260,346,650.29)	95.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,307,313,900.00	6,046,967,249.71	(260,346,650.29)	95.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,880,890,900.00	5,649,028,237.71	(231,862,662.29)	96.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,018,381,700.00	4,929,186,678.09	(89,195,021.91)	98.2
210101	Үндсэн цалин	3,101,862,800.00	3,028,492,377.16	(73,370,422.84)	97.6
210102	Нэмэгдэл	895,775,300.00	894,500,249.10	(1,275,050.90)	99.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	571,160,300.00	623,477,799.53	52,317,499.53	109.2
210104	Урамшуулал	449,583,300.00	382,716,252.30	(66,867,047.70)	85.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	627,183,000.00	613,681,998.62	(13,501,001.38)	97.8
210201	Тэтгэврийн даатгал	428,064,600.00	421,439,631.15	(6,624,968.85)	98.5
210202	Тэтгэмжийн даатгал	49,802,200.00	48,994,994.58	(807,205.42)	98.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	24,995,100.00	26,508,602.18	1,513,502.18	106.1
210204	Ажилгүйдлийн даатгал	24,854,200.00	23,172,422.41	(1,681,777.59)	93.2
210205	Эрүүл мэндийн даатгал	99,466,900.00	93,566,348.30	(5,900,551.70)	94.1
2104	Хангамж, бараа материалын зардал	4,392,100.00	3,464,700.00	(927,400.00)	78.9
210401	Бичиг хэрэг	1,396,400.00	965,000.00	(431,400.00)	69.1

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	997,500.00	397,600.00	(599,900.00)	39.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,998,200.00	2,102,100.00	103,900.00	105.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	107,807,500.00	40,156,000.00	(67,651,500.00)	37.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	107,807,500.00	40,156,000.00	(67,651,500.00)	37.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,271,000.00	28,079,691.00	(14,191,309.00)	66.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,996,600.00	26,933,335.00	(63,265.00)	99.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,977,100.00	-	(4,977,100.00)	-
210803	Даатгалын үйлчилгээ	302,000.00	-	(302,000.00)	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	494,900.00	479,656.00	(15,244.00)	96.9
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	161,300.00	-	(161,300.00)	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	987,400.00	666,700.00	(320,700.00)	67.5
210807	Газрын төлбөр	8,351,700.00	-	(8,351,700.00)	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,855,600.00	34,459,170.00	(46,396,430.00)	42.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	80,855,600.00	34,459,170.00	(46,396,430.00)	42.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	426,423,000.00	397,939,012.00	(28,483,988.00)	93.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	426,423,000.00	397,939,012.00	(28,483,988.00)	93.3
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	40,427,800.00	40,427,800.00	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	385,995,200.00	357,511,212.00	(28,483,988.00)	92.6
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-	-	
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-	-	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	350.00	350.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	172.00	172.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	158.00	158.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	168.00	168.00	-	100.0
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	159.00	159.00	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9.00	9.00	-	100.0
66	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	10.00	10.00	-	100.0

660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	10.00	10.00	-	100.0
--------	--	-------	-------	---	-------

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон
/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,240,687,002.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,240,687,002.00
122	Тусламжийн орлого	1,240,687,002.00
1221	Хандив тусламж /дотоод/	1,240,687,002.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,240,687,002.00
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	256,205,692.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	984,481,310.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	310,589,532.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	310,589,532.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	310,589,532.00
2107	Томилолт, зочны зардал	87,607,452.00
210701	Гадаад албан томилолт	87,607,452.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	222,982,080.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	222,982,080.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	930,097,470.00
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(930,097,470.00)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(930,097,470.00)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Үндэсний Урлагийн Их Театр нь 75 жилийн түүхэн хугацаанд “Эстрад концертын товчоо”, “Ардын дуу, танц, үндэсний хөгжмийн ансамбль”, “Ардын дуу, танцны Улсын ансамбль”, “Ардын дуу бүжгийн улсын чуулга”, “Улсын ардын дуу бүжгийн чуулга” хэмээн хэд хэдэн удаа нэршилээ өөрчилж ирсэн бөгөөд 1950 оны 12 дугаар сарын 01-ний өдрийг тус чуулга байгуулагдсан түүхэн он гэж тооцдог. Монгол улсын Засгийн газар 2002 онд “Эрдмийн” хэмээх цолыг 166 дугаар тогтоолоороо олгож “Үндэсний дуу бүжгийн Эрдмийн чуулга” хэмээн өөрчлөн 2016 онд Засгийн газрийн 129 дугаар тогтоолоор Үндэсний Урлагийн Их Театр гэж нэрлэсэн байна.

Театрын эрхэм зорилгыг “Монгол угсаатан, ястны утга соёлын өвийн сор дээжийг сурталчлах, судлах, сургах хийгээд үйлчлүүлэгч, харилцагч түншүүдийнхээ эрэлт шаардлагад нийцсэн орчин цагийн болон дэлхийн сонгомол бүтээлийг урлах чадвар бүхий өндөр боловсролтой хамт олны бүрдлийг нэгтгэсэн мэргэжлийн урлагийн төв байхын эрхэм зорилго оршино.” гэж тодорхойлжээ.

Театрын ерөнхий чиг үүрэг нь үндэсний урлагаар иргэдэд үйлчлэх бөгөөд байгууллагын менежментийн чадавхийг бэхжүүлэх бодлого, үйл ажиллагаа, бүтээгдэхүүний (урын сан) бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулах бодлого, үйл ажиллагааны тэргүүлэн чиглэлтэй ажиллаж байна.

Үүний зэрэгцээ, иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх, олон нийт, нийгмийг соён гэгээрүүлэх, соёл урлагаар үйлчилэх, соёл, урлагийг хөгжүүлж, олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, сурталчилах, соёлын өвийг хамгаалах, хөгжүүлэх, өвлөн уламжилж хадгалах, үнэ цэнэт байдлыг нэмэгдүүлэх зэрэг тэргүүлэх чиглэл баримталж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Үндэсний урлагийн их театр нь Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд харьяалагддаг, нийт 180 гаруй ажилтан, албан хаагч, уран бүтээлчдээс бүрдсэн хамт олонтой байгууллага байна. Тус театр нь Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулиудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг ба санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай зэрэг холбогдох хууль тогтоомжийг мөрддөг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газраас тус театрын 2025 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Үндэсний урлагийн их театрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Үндэсний урлагийн их театрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 868,293.2 мянган төгрөгөөр буюу 22.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	182,900.2	1,035,674.2	852,774.1
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	2,136,099.1	2,142,786.5	6,687.4
Үндсэн хөрөнгө	1,544,231.1	1,553,062.8	8,831.7
Нийт хөрөнгө	3,863,230.4	4,731,523.5	868,293.2
Өр төлбөр	-	27,580.4	27,580.4
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,863,230.4	4,703,943.1	840,712.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,863,230.4	4,731,523.5	868,293.2

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн данс байна. Үүнд:

- Сангийн яамны татан төвлөрүүлсэн тус театрын өөрийн орлого болох 926,085.6 мянган төгрөгийг авлагаар тооцон бүртгэсэн;
- ТӨБЗГ-ын тогтоолоор балансаас балансад автотээврийн хэрэгсэл, ССАЖЗЯ-аас компьютер, дагалдах хэрэгсэл үнэ төлбөргүй хүлээн авсан;
- Барилгын засвар болон засал чимэглэл хийх, сантехникийн бараа материал нийлүүлэх зэрэг гэрээт ажил хийсэн хувь хүмүүст төлөх гэрээний дүнгийн үлдэгдэл 30% болох нийт 27,580.4 мянган төгрөгийг богино хугацаат өр төлбөрөөр бүртгэсэн.

Тус байгууллага нь Си Ти Эс ХХК-ийн CTSYSTEM 6.5 санхүүгийн программ хангамжийг 2021 оноос хойш үйл ажиллагаандаа ашиглаж байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Үндэсний урлагийн их театр 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 6,368,133.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас бараа үйлчилгээний зардлыг 60,819.3 мянган төгрөгөөр бууруулж, 6,307,313.9 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 6,046,967.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 102,696.7 мянган төгрөгийг татан төлвөлрүүлсэн байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,649,028.3 мянган төгрөг буюу 99.4 хувьтай байна.

Төсвийн зарлагын “Соёл урлаг” хөтөлбөрийн хүрээнд 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 6,307,313.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1 арга хэмжээ 44 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Соёл урлаг (71702)	6,307,313.9	6,046,967.3	(260,346.6)	96.0
2	Үндсэн үйл ажиллагаа (80101)	5,624,803.3	5,542,987.7	(81,815.6)	99.0
3	Уран бүтээл хийлгэх (80214)	26,996.6	26,933.3	(63.3)	100.0
4	Ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж (80802)	385,995.2	357,511.2	(28,483.9)	93.0
5	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт (81855)	269,518.8	119,535.0	(149,983.8)	44.0

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлан, Төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

Бүтэц орон тоо: Тус театрын захирлын 2025 оны А/01 дүгээр “Байгууллагын бүтэц, зохион байгуулалт, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” тушаалаар бүтэц орон тоог 189 хүнээр батласан боловч 172 буюу 17 хүнээр дутуу ажилласан байна.

Хоол, унааны хөнгөлөлт: Тус театрын захирлын 2024 оны А/04 дүгээр тушаалаар ажилтанд ажлын 1 өдөрт хоолны 10.0 мянга, унааны 2.0 мянган төгрөгийн хөнгөлөлтийг тус тус олгож 677,423.1 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Гадаад томиллолт: МУ-ын Ерөнхийлөгчийн Киргиз, Тажикстан, БНЭАУ-д хийх айлчлалд оролцох 140 уран бүтээлчдийн зам хоногийн зардалд 87,607.4 мянган төгрөг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус театрын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 256,205.7 мянган

төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 984,481.3 мянган төгрөг, нийт 1,240,678.0 мянган төгрөгийн орлого төвлөрч, бараа үйлчилгээний зардалд 310,589.5 мянган төгрөг зарцуулж, 930,097.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус театрын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд шинэ уран бүтээлийн тайз засал 30,000.0 мянган төгрөг, шинэ уран бүтээлийн хувцас 60,000.0 мянган төгрөг, нийт 90,000.0 мянган төгрөгийн ажил үйлчилгээг харьцуулалтын аргаар худалдан авахаар баталсан боловч тендер зарлаагүй, худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Үндэсний урлагийн их театрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах өр төлбөрийн бүртгэл болон томилолтын зардалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ворлдвайд фاینэнс аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Уламбаяр, аудитор Д.Энхбаяр нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг чанарын хяналтын менежер Ж.Болормаа, захирал С.Оюунгэрэл, дараагийн шатны хяналтыг Санхүүгийн аудитын газрын аудитор С.Билгүтэй, аудитын менежер И.Эрдэнэцэцэг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Үндэсний урлагийн их театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсвийн 6,368,133.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 63,681.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд төсвийн тодотгол хийж нийт зарлагын гүйцэтгэл 6,046,967.2 мянган төгрөг гарснаас 1 хувиар буюу 60,469.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг шинэчлэн тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төлөвлөлтийн үе шатанд Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан 72 шалгуур үзүүлэлтээс тус театрт хамааралтай 29 шалгуур үзүүлэлтийг сонгож горим сорил хэрэгжүүлсэн ба алдаа зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Аудитаар хууль тогтоомжийн үл нийцэлтэй холбоотой алдаа зөрчил илрээгүй байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус театр нь цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 3,100,861.9 мянган төгрөгийн орлого, зарлагын 95 гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд цаг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, санхүүгийн тайлангийн данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 1,066,347.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулах 4 зөвлөмж өгсөн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар илэрсэн зөрчилд өгсөн 804.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг албан хаагчдын цалингаас суутган барагдуулж, 10,270.4 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	804.0	1	804.0	100
Зөвлөмж	4	10,270.4	4	10,270.4	100
Нийт дүн	6	119,663.2	6	119,663.2	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус театр нь 2025 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу толилуулаагүй бөгөөд санхүүгийн программын шинэчлэл хийх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 110,509.1 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 110,029.1 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 480.0 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийг өмнөх оны аудит хийсэн тайлангийн эцсийн үлдэгдэлтэй тулган шалгахад бараа материалын данс 423.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ нь дотоод эх үүсвэрээс хөрөнгө худалдан авсан дүнгээс 17.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, тайлагнасан;
- Өмнөх оны худалдан авах төлөвлөгөөний дагуу тендерт шалгарсан компани нь 2ш цондон бүрээ хүлээлгэн өгсөн боловч хөглөгөөний үзүүлэлт нь шаардлага хангахгүй байгаагаас засварт буцааж засуулсан боловч одоог хүртэл хүлээж аваагүй, бодитоор байхгүй 109,588.8 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэсэн зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9 дэх заалт, УСНББОУС 1, болон үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Залруулаагүй алдаа:

- Аялал жуулчлалын компаниудтай байгуулсан гадаадын жуулчдад үзвэр үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу олгосон ваучерын тооцоог түүвэрлэн шалгаж үзэхэд үзвэр үзсэн жуулчдын тоо зөрүүтэй, 480.0 мянган төгрөгийн ваучер засвартай байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9 дэх заалттай УСНББОУС 1, болон үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.” гэж заасныг мөрдөж ажиллах, ваучерын зарцуулалт, түүний бүртгэлд тавих хяналтыг сайжруулах

Аудитаар нийт 32,326.1 мянган төгрөгийн зөрчил² илрүүлж дараах 2 зөвлөмж өгсөн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өр төлбөрийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Барилгын засвар болон засал чимэглэл хийх, сантехникийн бараа материал нийлүүлэх зэрэг гэрээт ажлын үлдэгдэл 30 хувийн төлбөрийг тайлант оны 4 дүгээр улиралд төлөх хуваарьтай байсан боловч зарцуулалтын эрх нээгдээгүйгээс нийт 27,580.4 мянган

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төгрөгийг богино хугацаат өр төлбөрөөр бүртгэсэн нь УСНББОУС 1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9 дэх заалт болон эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг баримталж ажиллах.

2. Томилолтын зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Монгол Улсын Ерөнхийлөгчийн гадаад оронд хийсэн 2 удаагийн айлчлалын хүрээнд зохион байгуулсан урлагийн тоглолтын бүрэлдэхүүний гадаад томилолтын зардлыг ГХЯ-наас тус театрын нэмэлт санхүүжилтийн дансаар олгосон бөгөөд театрын захирлын тушаалаар нэр бүхий 140 хүнийг томилолтоор ажиллуулахаар баталсны 9 хүн нь тус театрын ажилтан биш бөгөөд эдгээр хүмүүст 4,745.7 мянган төгрөгийн томилолтын зардлыг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9 дэх заалт, УСНББОУС 1, "нийцсэн бөгөөд зохистой" байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6-д "тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх" гэсэн заалтыг баримталж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэл зөрүүтэй тайлагнасан.	1	423.3			1	423.3	1	423.3				
2	Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ зөрүүтэй тайлагнасан.	1	17.0			1	17.0	1	17.0				
3	Бодитоор байхгүй хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэсэн.	1	109,588.8			1	109,588.8	1	109,588.8				
4	Гадаадын жуулчдад үзвэр үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу олгосон ваучерын тооцоог зөрүүтэй тайлагнасан.	1	480.0			1	480.0			1	480.0		
	Дүн	4	110,509.1			4	110,509.1	3	110,029.1	1	480.0	1	480.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
1	Гэрээт ажлын үлдэгдэл-30%-ийн төлбөрийг өр төлбөрөөр бүртгэсэн байна.	1	27,580.4					1	27,580.4		
2	Тус театрын захирлын тушаалаар нэр бүхий 140 хүнийг томилолтоор ажиллуулахаар баталсны 9 хүн нь тус театрын ажилтан биш байна.	1	4,745.7					1	4,745.7		
	Дүн	2	32,326.1					2	32,326.1		